



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/137

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 45 дугаар зүйлийн 45.1 дэх зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хүн амын 80 хувийг Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношлогоонд хамруулахад шаардлагатай урвалж, оношлуур, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 50,000,000 (Тавин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Хавсралтаар батлагдсан бараа ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр  
сарын 27-ны өдрийн А/137 дугаар  
захирамжийн хавсралт

Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг зохион байгуулахад шаардлагатай урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн зардлын тооцоо

№	Эрт илрүүлэг үзлэгийн төрөл	Шаардлагатай эм хэрэгсэл тоног төхөөрөмж	Нэг бүрийн үнэ	Нэгж	Тоо ширхэг	Нийт үнэ	Нийт хүний тоо	Тайлбар
1	5-17 насны эрт илрүүлэг	Охидын толь	1000	ш	1400	1400000	1400	1 байгууллагад 50 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө
2	ЧШ /35 ба түүнээс дээш/	Сахарын тест	25000	50ш	224	5600000	11200	1 байгууллагад 8 хайрцаг нийт 28 ЭМБ-д өгнө
3	Цусан дахь Холестроны түвшин /40-с дээш/	Холестрины тест	30000	50ш	224	6720000	11200	1 байгууллагад 8 хайрцаг нийт 28 ЭМБ-д өгнө
4	ЗЦБ /40-с дээш/	ЗЦБ цаас	8000	ш	280	2240000	2800	1 байгууллагад 10 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө.
5	Умайн хүзүүний хавдар /30-60 нас/	Эмэгтэйчүүдийн толь	600	ш	2800	1680000	2800	1 байгууллагад 100 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө
		Спирт 96%-5 л	65900	5 литр	30	1977000		1 байгууллагад 5л нийт 28 ЭМБ-д өгнө. Мөн явуулын үйлчилээнд 2 ширхэг
		Эсийн шинжилгээний савх	30000	100ш	56	1680000	5600	1 байгууллагад 2 хайрцаг нийт 28 ЭМБ-д өгнө
		Тавиур шил	5000	50ш	56	280000	2800	1 байгууллагад 2 хайрцаг нийт 28 ЭМБ-д өгнө
6	Хэт авиан оношлогоо /Элэгний хорт хавдар/ /40-с дээш/	ЭХО гель	2000	ш	190	380000	19000	1 байгууллагад 5 ширхэг нийт 28 ЭМБ-д явуулын үйлчилээнд 50 ширхэгийг өгнө.
7	Сүрьеэ /15-с дээш/	Цэрний дээжний сав	500	ш	1400	700000	1400	1 байгууллагад 50 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө.
8	В, С вируст гепатит /15-аас дээш/	Элэгний В вирусн тест	900	ш	5600	5040000	5600	1 байгууллагад 200 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө.
		Элэгний С вирусн тест	800	ш	5600	4480000	5600	1 байгууллагад 200 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө.
9	ХДХВ/БЗДХ-тэмбүү /15-аас дээш/	ДОХ-ын тест	1100	ш	5600	6160000	5600	1 байгууллагад 200 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө.
		Тэмбүүгийн тест	1000	ш	5600	5600000	5600	1 байгууллагад 200 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө.
		Өндөг цоологч	1000	100ш	189	189000		1 байгууллагад 6 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө. Мөн явуулын үйлчилээнд 21 ширхэгийг өгнө.
10	Бусад	Үзлэгийн бээлий	33000	100ш	178	5874000		1 байгууллагад 5 ширхэг нийт 28 ЭМБ-д өгнө. Мөн явуулын үйлчилээнд 38 ширхэгийг өгнө.
Нийт дүн						50000000	80600	